

Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний
хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан



*Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт
үндэслэл муутайгаас хэрэгжилтэд сөргөөр
нөлөөлж байна*

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	2
Үндэсний аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Газрын захирал <i>Б.Баттуяа</i>	Бүлэг 1 2008-2012 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үр дүн	6
Хэлтсийн захирал-аудитын менежер <i>Г.Гүнжидмаа</i>	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, түүний үр дүн 	6
Ахлах аудитор <i>Д.Баттулга</i> <i>С.Сэрчхорол</i> <i>Г.Цэдэнбалжир</i> <i>С.Эрдэнэ</i> <i>У.Баярмаа</i>	Бүлэг 2 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 29.5 хувиар нэмэгджээ	9
Аудитор <i>Б.Саруул</i> <i>Ц.Эрдэнэчулуун</i> <i>Б.Нямхүү</i>	<ul style="list-style-type: none"> Хэрэгжих үндэслэл муутай төсөл, арга хэмжээ төлөвлөгдөж байна 	10
ҮАГ-ын нийцлийн аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээч нар	Бүлэг 3 Өмнөх жилүүдэд гарч байсан зөрчил арилаагүй байна	14
2013 оны 6 дугаар сар	<ul style="list-style-type: none"> Худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгож, гэрээ шууд байгуулсан зөрчил нилээдгүй байна 	16
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Бүлэг 4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 6.3 хувь нь дутуу, 17.5 хувь нь огт хэрэгжээгүй байна	17
www.mnao.mn	<ul style="list-style-type: none"> Орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт хангалтгүй байна Хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна 	19
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 261675 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	Дүгнэлт	23
	Холбогдох байгууллагын санал	24
	ҮАГ-аас өгөх тайлбар	28
	Зөвлөмж	29
	Хавсралт № 1	30
	Хавсралт № 2	31
ХАЯГ:	Ерөнхий аудиторын тушаал	53
Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс		

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АТГ	Авлигатай тэмцэх газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БУА	Барилга угсралтын ажил
БЗА	Барилга захиалагчийн алба
БЗД	Баянзүрх дүүрэг
БХИС	Батлан хамгаалахын их сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНБУ	Бүгд Найрамдах Болгар Улс
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЕС	Ерөнхий сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТС	Зам тээврийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХКТГ	Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталь
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХЗС	Хууль зүйн сайд
СЯ	Сангийн яам
ССАЖС	Соёл, спорт аялал жуулчлалын сайд
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНЖБТХ	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам, хувь нийлүүлсэн нийгэмлэг
УУС	Уул уурхайн сайд
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УДШ	Улсын дээд шүүх
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл

ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
СБД	Сүхбаатар дүүрэг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦЭК	Цөмийн энергийн комисс
ХС	Хөдөлмөрийн сайд
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШС	Шадар сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШӨХТГ	Шудрага өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

- 2008-2011 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үр дүн, үр нөлөө;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үндэслэлтэй төлөвлөгдсөн эсэх;
- Худалдан авах ажиллагаа зохих журмын дагуу хийгдсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бодитой тооцсон эсэх.

3. Хамарсан хүрээ

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдний эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудыг хамруулав. ТНЖБТХ, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.3-т заасны дагуу БХЯ, ЦЕГ, ХХЕГ, ТЕГ, АТГ-ын тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг шууд гэрээгээр гүйцэтгэсэн учир аудитад хамруулаагүй болно.

4. Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд,

- 2008-2011 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.
- Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан хөрөнгө оруулалтын судалгааг гаргуулан авч нэгтгэн дүгнэлээ.
- Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.
- Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын талаар шаардлагатай судалгаа, материалыг гаргуулан, ярилцлага, тодруулга авлаа.
- Худалдан авалт ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу хийгдсэн эсэхийг түүвэрлэн шалгав.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээний биелэлт, хэрэгжилт, үр дүнг түүвэрлэн шалгалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээний бодлого, төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Мөн улсын төсвийн орон нутагт эрх нь шилжсэн хөрөнгө оруулалтад аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид аудит хийлээ.

5. Стандартын талаархи мэдэгдэл


Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1 2008-2012 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үр дүн

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд, төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын бодлого, төсвийн чадавхид суурилан төлөвлөх шаардлагатай.

1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2004-2007 онд 669.9 тэрбум, 2008-2011 онд 2 956.9 тэрбум, 2012 онд 1 119.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, 2008 оныхоос 659.5 тэрбум, 2011 оныхоос 218.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын хэмжээ нэлээд хурдацтай өсч байгааг харуулж байна.

1.3 ДНБ болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн байдлаар графикаар харуулбал,



1.4 Монгол Улсын 2012 оны үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ оны үнээр 13.9 их наяд, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2.8 их наяд төгрөг буюу 25.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 0.6 их наяд төгрөг буюу 12.3 хувиар өссөн байна.

1.5 Монгол Улсын 2012 оны ДНБ-ийг 2010 онтой харьцуулахад 39.7 хувиар өссөн бол улсын төсвийн хөрөнгө оруулалт 57.7 хувь, 2011 онтой харьцуулахад ДНБ 20.5 хувь, хөрөнгө оруулалт 19.5 хувиар тус тус өссөн байна.

1.6 2008-2012 оны нэгдсэн төсвийн зарлагын дүнд эзлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

(тэрбум төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Гүйцэтгэл (оноор)				
		2008	2009	2010	2011	2012
1	Нэгдсэн төсвийн орлого	2 170.4	1 994.0	3 122.5	4 227.2	4 881.2
2	Нэгдсэн төсвийн зарлага	2 466.8	2 336.6	3 080.7	4 997.0	6 017.8
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	460.0	374.6	473.2	901.4	1 119.5
4	Төсвийн нийт зардалд эзлэх хөрөнгө оруулалтын хувь	18.6	16.0	15.4	18.0	18.6

*Эх сурвалж, 2010, 2011, 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.7 2008-2012 оны нэгдсэн төсвийн зардалд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин дунджаар 17.3 хувь байна.

1.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүтцийг авч үзэхэд барилга байгууламжид 80 орчим, тоног төхөөрөмжид 15 орчим, их засварын зардалд 5 орчим хувь нь тус тус зарцуулагджээ.

2008-2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бүтцээр нь ангилбал

(тэрбум.төгрөг)

Үзүүлэлт	2008 он		2009		2010		2011		2012	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Барилга байгууламж	327.3	71.2	308.7	82.0	406.3	85.9	740.0	82.4	966.9	86.4
Их засвар	27.4	5.9	11.6	3.0	28.2	6.0	38.4	4.3	52.3	4.7
Тоног төхөөрөмж	105.3	22.9	54.3	15.0	38.7	8.2	123.0	13.4	100.3	8.9
Нийт дүн	460.0	100.0	374.6	100.0	473.2	100.1	901.4	100.1	1119.5	100.0

1.9 Улсын төсвийн хөрөнгөөр 2008-2012 онд санхүүжигдэн ашиглалтад орсон барилга байгууламж, дэд бүтцийг дараах хүснэгтэд харуулав.

Үзүүлэлт	Х/н	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он
Нийт хөрөнгө оруулалт	тэрбум төгрөг	460.0	374.6	473.2	901.4	1 119,5
Хатуу хучилттай авто зам	км	128.6	119.9	274.2	334.6	151.1
Хайрган хучилттай авто зам	км	45.8	40.1	56.5	0.0	0.0
Төмөр бетон гүүр	у/м	114.5	498.2	602.3	374.1	545.1
Эрчим хүчний шугамд холбогдсон сум	тоо	32	19	17	6	5
Ашиглалтад орсон ЦДШ	км	2 241.0	1 091.0	1 121.0	459.3	742.7
Ашиглалтад орсон ЕБС	суудлын тоо	3 930	5 900	4 668	5 880	11558
Ашиглалтад орсон цэцэрлэг	орны тоо	720	1 825	2 460	3 270	3200
Ашиглалтад орсон соёлын төв	суудлын тоо	1 150	3 889	2 890	1 780	1890
Сургуулийн дотуур байр	орны тоо	340	1 089	1 045	930	930
Сургуулийн спорт заал	м2	2 880.0	3 870.0	2 016.0	3 000.0	2718
Ашиглалтад орсон хүн эмнэлэг	тоо	9	14	18	16	15
Ашиглалтад орсон хүн эмнэлэг	орны тоо	110	285	325	310	200
Инженерийн хийцтэй худаг	тоо	802	252	258	652	463
Услалтын систем	тоо	5 753.7	3 733.2	3 155.0	1 531.1	1302.1
Услалтын системийн засвар	га	3 070.5	1 588.5	780.0		1006.6
Дулааны шугам	га	7.8	7.5	5.8	0.5	
Бохир усны шугам	км	16.0	5.8	9.7	9.2	
Цэвэр усны шугам	км	15.4	8.5	36.9	27.3	
Үерийн хамгаалалтын далан	км	3.2	1.0	4.5	12.3	

*Эх сурвалж: Сангийн яамны хөрөнгө оруулалтын хэлтэс

1.10 2008-2012 оны хооронд бүтээн байгуулалтын томоохон арга хэмжээ болох олон улсын чанартай зам (Алтанбулаг-УБ-Чойр-Замын-Үүд), баруун бүсийн босоо тэнхлэгийн зам, УБ хотыг аймгийн төвүүдтэй холбох зам зэрэг нийт 4300 орчим км хатуу хучилттай зам барихаар төлөвлөсөн боловч 1108.4 км зам тавигдсан нь техникийн болон хүний нөөцийн хүчин чадлыг тооцон төлөвлөөгүйтэй холбоотой байна.

1.11 2008-2012 онд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн дотор олон жилээр үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээ нилээд байна. Тухайлбал, (сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний			Төсөвт өртөг	
Хэрэгжих хугацаа	тоо	хувь	дүн	хувь
2001-2010	1	0.3	7.3	0.5
2004-2010	1	0.3	7.8	0.5
2005-2010	3	0.8	3.7	0.2
2006-2010	6	1.7	14.4	0.9
2007-2009	4	1.1	16.3	1.0
2007-2010	50	13.9	148.4	9.3
2007-2011	3	0.8	12.8	0.8
2008-2009	4	1.1	19.1	1.2
2008-2010	77	21.4	140.0	8.7
2008-2011	24	6.7	117.3	7.3
2008-2012	2	0.6	29.4	1.8
2009-2010	32	8.9	49.6	3.1
2009-2011	11	3.1	35.3	2.2
2009-2012	2	0.6	7.0	0.4
2009-2013	1	0.3	2.1	0.1
2010-2011	104	28.9	260.1	16.2
2010-2012	28	7.8	373.2	23.3
2010-2013	7	1.9	360.2	22.5
Дүн	360	100.0	1 604.0	100.0

1.12 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт олон жил дамжин удаашрах нь өртөг зардал өсөх, үр өгөөж буурах, улмаар хэрэглэгч, ашиглагчийн шаардлагыг хангахгүйд хүргэх сөрөг үр дагавартай байна.

1.13 2008-2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4 806 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд 136.4 тэрбум төгрөгийн ажил хэрэгжээгүй, 132.6 тэрбум төгрөгийн ажил дутуу хэрэгжсэн, батлагдсан хөрөнгө оруулалтаас 224.6 тэрбум төгрөгийг ашиглаж чадаагүй нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон худалдан авах ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

1.14 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх гол шалтгаан нь захиалагчийн зүгээс тендер зарлах, гэрээ байгуулах асуудлыг оройтуулах, санхүүжилт олон шат дамжлага дамжин хугацаа алдах, гүйцэтгэгчийн зүгээс техникийн болон хүний нөөцийн хүчин чадал хүрэлцэхгүй байх, хэд хэдэн ажлыг зэрэг эхлүүлэх, батлагдсан зураг төсөв өөрчлөгдөх, оновчтой зохион байгуулж чадаагүй зэрэгтэй холбоотой байна.

1.15 2008-2012 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж үзэхэд макро эдийн засаг сүүлийн үед огцом өөрчлөгдөж байгаа ч эрдэс баялгийн нөөцийг бодит хөрөнгө болгон хувиргахын тулд хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, үр ашигтай хэрэгжүүлэх Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.16 2008-2011 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 91.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгснөөс 56.8 хувь, 85.1 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тавигдсанаас 69.2 хувь, 109 зөвлөмж өгснөөс 87.2 хувь нь тус тус хэрэгжсэн байна.

Бүлэг 2 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 29.5 хувиар нэмэгджээ

2.1 УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтот суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөр”-т хөрөнгө оруулалтын ерөнхий чиглэлийг тусгасан байна.

2.2 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 1 964.5 тэрбум төгрөгийн 111 арга хэмжээ тусгагдсан боловч улсын төсвөөс 864.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 49 арга хэмжээнд 304.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдаж, 223.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.


2.3 “Төсвийн хязгаар батлах тухай” Засгийн газрын 2011 оны 261 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1 057.7 тэрбум төгрөгт багтааж боловсруулахыг ТЕЗ нарт даалгажээ.

2.4 Гэвч Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3 570.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1406 арга хэмжээнд 1 489.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1 208.4 тэрбум төгрөг болж, 281.1 тэрбум төгрөгөөр хасагдсан байна.

2.5 2012 онд төсвийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 275.3 тэрбум төгрөгөөр буюу 22.8 хувиар өсжээ.

(тэрбум төгрөгөөр)

2.6 Хөрөнгө оруулалтад батлагдсан төсөл, арга хэмжээг бүтцээр нь авч үзвэл, барилга байгууламж барихад 85.0 хувь, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авахад 10.0 хувь, их засварын зардалд 5.0 хувийг зарцуулахаар баталсан байна.



2.7 Тайлант онд барилга байгууламжид зарцуулахаар батлагдсан хөрөнгө нь өмнөх оныхоос 261.1 тэрбум төгрөг буюу 25.2 хувиар, тоног төхөөрөмж худалдан авах зардал 8.8 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар, их засварын зардал 5.4 тэрбум төгрөгөөр буюу 10.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2.8 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг салбараар ангилж үзвэл,

(тэрбум төгрөгөөр)

№	Салбар	Мөнгөн дүн	Эзлэх хувь
1	Дэд бүтэц	601.2	49.8
2	Нийгэм	336.1	27.8
3	Үйлдвэр, хөдөө аж ахуй	49.9	4.1
4	Байгаль орчин	21.3	1.8
5	Бусад	199.9	16.5
	Нийт дүн	1208.4	100.0

2.9 2012 онд улсын төсвөөс батлагдсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр харуулбал,

(сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Төсөвт өртөг	2012 оны төсөв	Санхүүжилт хийсэн		Нийт санхүүжилт	Үлдэгдэл
				2012-12-31	2013-03-31		
1	ЕТГ	1 192.2	1 192.2	190.9	774.9	965.9	226.3
2	УИХ	1 145.0	1 145.0	1 124.1	0.0	1 124.1	20.9
3	ЕС	106 275.3	31 365.3	20 016.7	10 401.2	30 417.9	947.4
4	ЗГХЭГ	426 739.0	31 480.9	26 736.6	2 799.6	29 576.2	1 904.7
5	ГХС	11 426.4	7 116.0	5 076.1	1 704.3	6 780.4	335.6
6	СС	43 457.0	30 782.9	11 675.9	3 677.3	15 690.8	15 092.1
7	БХС	43 578.5	15 866.3	14 273.9	326.2	14 600.1	1 266.2
8	ЭМС	135 809.0	82 563.0	56 671.3	16 136.7	72 946.0	9 617.0
9	ҮХЦ	50.2	50.2	47.8	2.4	50.2	0.0
10	УДШ	193.0	193.0	186.8	0.0	186.8	6.2
11	ШЕЗ	3 518.2	1 790.2	1 790.2	0.0	1 790.2	0.0
12	УЕП	5 423.3	5 123.3	4 862.2	261.1	5 123.3	0.0
13	ҮАБЗ	64.5	64.5	62.5	0.0	62.5	2.0
14	ҮАГ	75.0	75.0	75.0	0.0	75.0	0.0
15	ҮСХ	407.5	407.5	332.0	0.0	332.0	75.5
16	СЗХ	250.0	250.0	240.8	0.0	240.8	9.2
17	ТАЗ	40.2	40.2	40.0	0.0	40.0	0.2
18	ЦАУЗБК	33.0	33.0	33.0	0.0	33.0	0.0
19	ШС	20 471.7	14 792.5	11 710.9	2 443.8	14 529.9	262.6
20	АТГ	1 407.6	1 088.1	975.4	112.7	1 088.1	0.0
21	БОНХС	24 177.0	21 348.0	12 552.5	8 003.1	20 590.6	757.4
22	ХЗС	78 987.7	44 362.4	36 943.3	6 105.7	43 118.1	1 244.3
23	БХБС	151 289.6	70 070.9	47 278.3	17 320.9	64 599.1	5 471.8
24	БШУС	259 220.0	133 908.7	95 668.0	24 573.7	120 434.2	13 474.5
25	ЗТС	1 060 916.6	391 179.4	344 768.4	28 821.0	373 589.4	17 590.0
26	ССАЖС	96 878.5	49 334.9	32 278.4	12 547.6	44 826.0	4 508.9
27	УУС	29 762.9	5 032.5	782.0	3 319.9	4 101.9	930.6
28	ҮХААС	128 275.4	49 869.7	31 748.1	15 145.7	47 052.4	2 817.3
29	ХС	36 156.0	19 361.0	12 598.5	2 444.6	15 043.1	4 317.9
30	ХАХНХС	59 207.2	50 991.8	46 873.7	2 782.9	49 656.6	1 335.2
31	ЭЗХС	16 444.0	12 586.2	11 147.9	1 271.0	12 418.9	167.3
32	ЭХС	399 350.4	134 925.0	106 632.1	21 790.5	128 422.5	6 502.5
	НИЙТ	3 142 221.9	1 208 389.6	935 397.4	182 766.6	1119505.9	88 883.7

*Эх сурвалж: Сангийн яамны төрийн сангийн газар

2.10 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 142.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 208.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээс 2013 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 88.9 тэрбум төгрөгийн эрх нээгдээгүй үлджээ.

Хэрэгжих үндэслэл муутай төсөл, арга хэмжээ төлөвлөгдөж байна

2.11 2012 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс томоохон өртөг бүхий 137 төсөл арга хэмжээнд дүн шинжилгээ хийж үзэхэд,

- ✚ ТЭЗҮ байхгүй 13 төсөл, арга хэмжээ буюу 9.5 хувь;
- ✚ Газрын зөвшөөрөлгүй 12 төсөл, арга хэмжээ буюу 8.7 хувь;
- ✚ Инженер геологи болон геодезийн дүгнэлтгүй 12 арга хэмжээ буюу 8.7 хувь;
- ✚ Техникийн нөхцөл аваагүй 10 төсөл, арга хэмжээ буюу 7.2 хувь;
- ✚ Боловсруулсан зураг төсөлгүй болон зураг төсөлд магадлал, экспертиз хийгдээгүй 14 төсөл, арга хэмжээ буюу 10.2 хувь;
- ✚ Сонгон шалгаруулалт хийгдээгүй болон ажил эхлэх зөвшөөрөл аваагүй 37 төсөл, арга хэмжээ буюу 27.0 хувийг тус тус эзэлж байна.

2.12 Дээрх төсөл, арга хэмжээний 30.7 хувь буюу 3 арга хэмжээ тутмын нэг нь Барилгын тухай хуулийн 15.2¹, Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.2²- дах заалтуудыг тус тус зөрчин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна

2.13 Монгол Улсын 2010-2013 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд инженерийн сүлжээ, дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй дараах барилга байгууламжийг барихаар оруулсан байна. Тухайлбал,

- + *Үндэсний архивын ерөнхий газрын барилгын ажлыг гүйцэтгэгчээр “Нийслэл-Өргөө” ХХК 2010 онд (7 722.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй) шалгарч, 2010 онд 500.0 сая, 2011 онд 4 000.0 сая, 2012 онд 3 222.0 сая, нийт 7 722.0 сая төгрөг зарцуулаад байна. Тус барилгын гадна дулааны шугамын ажлын зөвшөөрлийг 4 дүгээр төрөхөөс татахаар техникийн нөхцөл олгогджээ. 2013 онд тус барилгад 1 298.0 сая төгрөг буюу барилгын суурийн газар шорооны өндөржүүлэлтэд 778.0 сая төгрөг батлагдсан;*
- + *4 дүгээр амаржих газрын барилгын (19 000.0 сая төгрөгийн төсөвт өртөг) ажлын гүйцэтгэгчээр 2010 онд “Нийслэл-Өргөө” ХХК, “Пума констракшн” ХХК-ны түншлэл 18 707.3 сая төгрөгт шалгарчээ. 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 17 807.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан. БУА-ын гүйцэтгэл 60.0 хувьтай атал 95.0 хувийн санхүүжилт авсан байна. ЭМЯ-ны барилга захиалагчийн албанаас барилгын материалын үнийн зөрүү 7 550.4 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гаргасан нь үндэслэл муутай байна..*

2.14 2012 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ангиллын дагуу төлөвлөөгүй тохиолдол байна. Тухайлбал,

- + *БХБС-ын багцад хөрөнгө оруулалтын ангилалд 1 500.0 сая төгрөгийн их засварын ажил тусгасан;*
- + *ЭМС-ын багцад хөрөнгө оруулалтын ангилалд 1 100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар тусгасан.*

2.15 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэт жижиглэх, санхүүжилтийг бага төлөвлөснөөс хэрэгжилт хангалтгүй болох, хөрөнгө тарамдах, үр дүн буурах нөхцөл бүрдэж байна. Тухайлбал,

ЭХС-ын багцад

- + *Увс аймгийн Малчин-Тэс сумын 35 кв-ын 115 км ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх 2012-2013 онд 3 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажилд 2012 онд 89.0 сая;*
- + *Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцын хүчин чадлыг 2*200 МВА болгож нэмэгдүүлэх 2012-2013 онд 8 000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажилд 2012 онд 200.0 сая төгрөг л баталсан байна.*

2.16 2012 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн зарим хөрөнгө оруулалтын төслийн өртгийг өмнө нь хэрэгжсэн ижил төстэй төслүүдийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолоор баталсан “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн

¹ Барилгын тухай хуулийн 15.2¹-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно”,

² СС-ын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.2²-т “Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэхээр тооцож буй төсөл, барилга байгууламж нь ...хайгуул нь хийгдэж дүгнэлт гарсан, зураг төслийн ажил нь экспертизээр батлагдсан, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудал бүрэн шийдэгдсэн, үр ашигтай нь техник-эдийн засгийн тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажил эхлэх нөхцлийг хангасан байна

жишиг үнэлгээ батлах тухай”³ журмыг баримтлан бодитой тооцохгүй байна. Тухайлбал,

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	(сая төгрөгөөр)	
			Баталсан жишиг үнээр	Зөрүү
Улаангом (Тээлийн гүүр)-Хяргас нуур чиглэлийн 100 км авто замын зураг төслийг бэлэн болгож, замын ажлыг эхлүүлэх (Увс)	2011-2014	45 000.0	42 600.0	(2 400.0)
Налайх (4 дүгээр зөрлөг)-Зуунмод чиглэлийн 25 км хатуу хучилттай авто зам (Улаанбаатар)	2012-2013	14 475.2	10 650.0	(3 825.2)
Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км авто замын шинэчлэл (Улаанбаатар)	2012-2013	13 032.8	12 865.2	(167.6)
Нарийний голын 325 у/м төмөр бетонон гүүр (Увс,Тэс)	2011-2013	5 380.2	4 375.0	(1 005.2)
Үүрийн голын 350 у/м төмөр бетонон гүүр (Хөвсгөл, Цагаан-Үүр/)	2011-2013	8 163.8	4 725.0	(3 438.8)
Хэрлэн голын төмөр бетонон гүүр (Дорнод, Хөлөнбуйр) 344,2 у/м	2012-2014	6 200.0	4 646.7	(1 553.3)
Манхан-Дарви чиглэлийн 100 км, хатуу хучилттай авто зам (Ховд)	2010-2013	42 981.8	42 600.0	(381.8)

2.17 Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртгийг 381.8-3 825.2 сая төгрөгөөр илүү тооцож төлөвлөсөн байна.

2.18 Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа өөр салбарын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бусад салбарт хэрэгжүүлэхээр баталсан байлаа. Тухайлбал,

- ✚ **БХБС-ын багцад батлагдсан:** БОНХС-ын багцад хэрэгжүүлэх Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл 500.0 сая;
- ✚ **ЗТС-ын багцад хэрэгжүүлэх,** Хангайн бүсийн босоо тэнхлэгийн дагуу хатуу хучилттай автозамын ажлын зураг төсөв, 268 км (Булган, Бага Илэнх-Намнан уул, Булган-Дашинчилэн, Рашаант) 670.0 сая, Орхон, Сэлэнгэ голууд дээгүүр гүүр барих зураг төсөв (Булган) 40.0 сая, Ширээгийн голын төмөр бетон гүүрийн зураг төсөв, 250 у/м (Завхан Цагаанхайрхан) 50.0 сая;
- ✚ **ХЗС-ын багцад хэрэгжүүлэх,** Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэст хяналтын камер (wireless)-ийн системийн өргөтгөл 300.0 сая төгрөгийг тус тус баталжээ.

2.19 БХБС-ын багцад ийнхүү бусад салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчлан баталсан нь тухайн төсөл, арга хэмжээг хэн хэрэгжүүлэх, мэргэжлийн зүгээс хэрхэн хяналт тавих асуудлыг тодорхойгүй болгосон байна.

2.20 Мөн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажил нь тодорхой бус дараах арга хэмжээнүүдийг хөрөнгө оруулалтын жагсаалтад ерөнхий агуулгаар нь тусгажээ. Үүнд,

- ✚ Бүтээн байгуулалтад бодит хөрөнгө оруулалтын ажил хийх (Говь-Алтай 400.0 сая);
- ✚ Аймгийн бүтээн байгуулалт (Говь-Алтай 300.0 сая);
- ✚ Нийслэлийн бүтээн байгуулалт (УБ БЗД 1 000.0 сая);
- ✚ Хан-Уул хөгжил хөтөлбөр (УБ.Хан-Уул, Багануур, Багахангай дүүрэг 1 000.0 сая);
- ✚ Тохилог орчин хөтөлбөр (Орхон 500.0 сая);
- ✚ СХД-ийг бүсчлэн хөгжүүлэх хөтөлбөр (УБ.Толгойт, Өнөр, Баянхошуу 1 820.0 сая);
- ✚ Орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 3 000.0 сая төгрөгийг тус тус баталсан байна.

2.21 Ингэж хийх ажил нь тодорхой бус арга хэмжээ төлөвлөснөөс тухайн арга хэмжээний эцсийн үр дүн, хүрэх түвшин тодорхойгүй байна.

2.22 Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар УИХ-ын гишүүдийн санал болгосноор 93.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 416 арга хэмжээнд 76.0 тэрбум төгрөг тусгагдсан байна. Тухайлбал,

³ Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолоор баталсан “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай”

- + Л.Гүндалай гишүүний “Буддын шашныг хөгжүүлэх” төсөл 220.0 сая;
- + Ц.Нямдорж, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн нарын “Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих төсөл” 300.0 сая, “Гэр хөтөлбөр” 360.0 сая Увс аймагт;
- + Ж.Сүхбаатар “Нутгийн салхи үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр” 50.0 сая;
- + Н.Батбаяр “Гэр хөтөлбөр” Архангай аймаг 271.2 сая;
- + Ч.Улаан “Гэр хөтөлбөр” Сүхбаатар аймаг 200.0 сая;
- + Ц.Мөнх-Оргил “Монгол гэр” хөтөлбөр УБ.Баянгол дүүрэг 200.0 сая;
- + С.Эрдэнэ “Нэн ядуу 180 айлыг орон гэртэй болгох” УБ.Баянгол дүүрэг 270.0 сая;
- + Д.Дондог “Малжуулах төсөл” Төв аймаг 100.0 сая;
- + Б.Батбаяр “Эко аялал” Баянхонгор аймагт 90.0 сая;
- + Г.Баярсайхан “Шинэ Чингэлтэй хөтөлбөрийн хүрээнд” 45 000 ширхэг 448.8 сая төгрөгийн ус зөөх сав худалдан авах;
- + ҮХААС-ын баацад, “Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх” 1 000.0 сая, “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих сурталчилгааны тоног төхөөрөмж 130.0 сая, “Зөгийн аж ахуйг хөгжүүлэх “Сүхбаатар зөгий” хөтөлбөрт 300.0 сая, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрт 1 000.0 сая, “малчдын бүлэг хоршоодыг дэмжих, чадваржуулах” хөтөлбөрт 340.0 сая төгрөгийг иргэдэд дэмжлэгээр олгох.

2.23 УИХ-ын гишүүдийн санал болгосон дээрх төсөл, хөтөлбөр нь хөрөнгө оруулалтын чанартай бус төсөл, арга хэмжээнүүд байна.

2.24 Улсын хэмжээний дунд хугацааны хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг оновчтой боловсруулж, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, санхүүжилтийн бүх эх үүсвэрийг хамруулан, цогц байдлаар тооцож, зураг төсөв, ТЭЗҮ-тэй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Бүлэг 3 Өмнөх жилүүдэд худалдан авах ажиллагаанд гарч байсан зөрчил арилаагүй байна

Ерөнхий мэдээлэл


3.1 ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ТЕЗ нар тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оны эхний 1 дүгээр сард зарлан мэдээлэх ба барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээний сонгон шалгаруулалтыг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор эхлүүлэхээр заасан.

3.2 2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1406 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд ТЕЗ нар худалдан авах ажиллагааг 2302 багц болгон зохион байгуулсан байна.

3.3 Улсын хэмжээнд 2012 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1589 төсөл, арга хэмжээ буюу 69.0 хувь, харьцуулалтын аргаар 505 төсөл, арга хэмжээ буюу 21.9 хувь, шууд гэрээ байгуулах аргаар 199 төсөл, арга хэмжээ буюу 8.6 хувь, хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 9 төсөл, арга хэмжээ буюу 0.4 хувь, нийт 2302 төсөл, арга хэмжээний худалдан авах арга хэмжээг зохион байгуулжээ. (Хавсралт № 1)

3.4 2012 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг графикаар харуулбал,

(сая төгрөгөөр)



3.5 Засгийн газрын худалдан авах ажиллагааны (e-procurement.mn) цахим хуудаст нийт 323 байгууллага нэвтрэх эрх авч, 6718 тендерийн урилга, 4500 тендер шалгаруулалтын үр дүн цахим хуудас⁴т нийтлэгдсэн байгаагаас үзэхэд тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлж байгаа хэдий ч үр дүнг мэдээлэх талаар хангалтгүй ажиллаж байна.

⁴ Сангийн яамны худалдан авах ажиллагааны тайлан

3.6 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.7⁵-д заасны дагуу ТЕЗ нарын ирүүлсэн 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний системд нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим сүлжээнд нийтлэгдсэн тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн байна.

3.7 ТЕЗ нарын 2012 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээс үзэхэд 2 төсвийн ерөнхийлөн захирагч 90-100 буюу “маш сайн”, 2 төсвийн ерөнхийлөн захирагч 80-89 оноо буюу “сайн”, 15 төсвийн ерөнхийлөн захирагч 60-79 оноо буюу “хангалттай”, 10 төсвийн ерөнхийлөн захирагч 40-59 оноо буюу “хангалтгүй”, 2 төсвийн ерөнхийлөн захирагч “муу” үнэлгээ авсан бөгөөд 3 төсвийн ерөнхийлөн захирагч тайлан огт ирүүлээгүй байна.

3.8 ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал,

№	ТЕЗ	Оноор/ үнэлгээ/ хувиар				
		2008	2009	2010	2011	2012
1	БОНХС	34	9	0	61	76
2	БХБС	65	42	56	60	55
3	ЗТС					71
4	БХС	71	80	80	58	64
5	БШУС	67	54	60	60	0
6	ГХС	46	0	40	41	62
7	СС	64	60	69	64	55
8	ССАЖС					0
9	ҮХААС	60	61	66	63	64
10	ХС	76	65	61	84	38
11	ХАХНХС					49
12	ХЗС	49	60	60	61	73
13	ЭЗХС					56
14	ЭМС	86	45	61	0	65
15	ЭХС	71	51	56	58	76
16	УУС					54
17	АТГ	62	58	60	80	71
18	ЕТГ	-	-	64	60	51
19	ЗГХЭГ	60	65	63	64	60
21	ЕС	78	61	67	75	78
22	СЗХ	75	0		62	60
23	СЕХ	60	70			60
24	ТАЗ	92	0		96	67
25	ТӨХ	36	58	41	40	50
26	УДШ	92	0	69	74	63
27	УЕП	80	100	85	0	56
28	ҮХЦ	85	93	100	80	96
29	ҮАБЗ					85
30	ҮСХ	70	72	57	97	80
31	ХЭҮК	76	0	94		45
32	ШС	0	75	60	0	33
33	ШЕЗ	85	86	89	62	100
ДУНДАЖ		50.7	41.6	47.3	42.9	57.5

* Эх сурвалж Сангийн яамны худалдан авах ажиллагааны 2012 оны тайлан

⁵ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.7-д Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дүгнэж, дараа жилийн хний улиралд Засгийн газарт тайлагнана.

3.9 Дээрх судалгаанаас харахад худалдан авах ажиллагааны хэрэгжилт, зохион байгуулалтад өгсөн үнэлгээ 2012 онд өмнөх жилүүдийнхээс бага зэрэг өсчээ.

3.10 2012 онд ШӨХТГ-т худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүйтэй холбоотой 122 гомдол ирсний 74-ийг үндэслэлтэй гэж үзэн тендер шалгаруулалтыг дахин явуулах шийдвэр гаргажээ.

Худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгож, гэрээ шууд байгуулсан зөрчил илэрчээ

3.11 ТЕЗ-дын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байдлыг авч үзэхэд нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх шаардлагатай худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулсан зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- ✚ ССАЖЯ гадна дотор фасадын засварыг 5 багц болгон 356.4 сая төгрөгийн ажлыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан нь босго үнийг 8.0-48.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
- ✚ Тус яам 162.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тавилга, тоног төхөөрөмжийг тендер зарлалгүй 12 аж ахуйн нэгж, байгууллагатай шууд гэрээ байгуулж авчээ.

3.12 Худалдан авах ажиллагааны бичиг баримтыг боловсруулахдаа тендер оролцогчдод тавих шалгуур үзүүлэлт, нөхцөл, аргачлалыг бүрхэгдүүлсэн, техникийн нөхцөл болон өгөгдлийг будлиантуулсан тохиолдол гарч байна. Тухайлбал,

- ✚ ИНЕГ-т шаардлагатай нисэхийн аюулгүй ажиллагааны тоноглогдсон автомашины тендерийн бичиг баримтыг задалж үзэхэд жирийн Ланд Крузер 200 автомашины үзүүлэлт байлаа.

3.13 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1⁶, 21.4⁷ дэх заалтуудыг ТЕЗ-д баримталж ажиллаагүй нь худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгох, тендер шалгаруулалт хуулийн хугацаандаа хийгдэхгүй байх, үнэлгээ буруу хийгдэх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна.

⁶ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1-д худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана

⁷ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.4-т заасны дагуу захиалагч цахим хуудаст тендерийн урилгыг нийтэлж, шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх ёстой

Бүлэг 4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 6.3 хувь нь дутуу, 17.5 хувь нь огт хэрэгжээгүй байна

4.1 2012 онд 920.0 тэрбум төгрөгийн 2090 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн боловч 76.4 тэрбум төгрөгийн 255 ажил дутуу, 211.9 тэрбум төгрөгийн 100 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үүнийг ТЕЗ -даар харуулбал,

(сая төгрөгөөр)

№	ТЕЗ	Нийт төсөл, арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Хэрэгжээгүй	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗТС	172	391 179.4	115	197 298.5	50	25 433.0	7	168 447.9
2	ЭХС	85	134 925.0	81	130 843.0	2	2 987.0	2	1 095.0
3	БШУС	248	133 908.7	173	123 176.6	52	8 700.5	23	2 031.6
4	ЭМС	293	82 563.0	268	70 540.6	22	11 782.4	3	240.0
5	БХБС	178	70 070.9	144	64 228.1	31	4 166.4	3	1 676.4
6	ХАХНХС	97	50 991.8	77	43 810.2	11	3 950.0	9	3 231.6
7	ҮХААС	75	49 869.7	55	47 107.4	14	2 199.4	6	562.9
8	ССАЖС	165	49 334.9	144	42 001.9	16	4 103.6	5	3 229.4
9	ХЗС	197	44 362.4	190	43 220.7	5	339.6	2	802.1
10	ЗГХЭГ	173	31 480.9	130	26 628.7	28	3 425.8	15	1 426.4
11	ЕС	82	31 365.3	80	30 930.0			2	435.3
12	СС	96	30 782.9	85	13 360.6	2	847.6	9	16 574.7
13	БОНХС	96	21 348.0	89	9 803.0	3	5.0	4	11 540.0
14	ХС	69	19 361.0	59	15 512.3	9	3 548.7	1	300.0
15	БХС	19	15 866.3	17	13 884.5	2	1 981.8		
16	ШС	84	14 792.5	78	14 707.0	1	23.4	5	62.1
17	ЭЗХС	17	12 586.2	11	11 445.5	3	985.2	3	155.5
18	ГХС	37	7 116.0	37	7 116.0				
19	УЕП	16	5 123.3	14	4 975.7	2	147.6		
20	УУС	5	5 032.5	3	3 262.4	2	1 770.1		
21	ШЕЗ	4	1 790.2	4	1 790.2				
22	ЕТГ	4	1 192.2	3	1 042.2			1	150.0
23	УИХ	35	1 145.0	35	1 145.0				
24	АТГ	3	1 088.1	3	1 088.1				
25	ҮСХ	12	407.5	12	407.5				
26	СЗХ	4	250.0	4	250.0				
27	УДШЕШ	3	193.0	3	193.0				
28	ЕА	3	75.0	3	75.0				
29	ҮАБЗ	3	64.5	3	64.5				
30	ҮХЦ	3	50.2	3	50.2				
31	ТАЗ	2	40.2	2	40.2				
32	ЦАУЗБУК	2	33.0	2	33.0				
Улсын төсөв		2282	1 208 389.6	1927	920 031.6	255	76 397.1	100	211 960.9
33	НЗД	136	115 317.4	102	64 728.2	27	40 047.2	7	10 542.0
Нийт дүн		2418	1 323 707.0	2029	984 759.8	282	116 444.3	107	222 502.9

*Задаргааг хавсралт №-2-т харуулав

4.2 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ дараах шалтгааны улмаас хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- Тендер оройтож зарлагдсан, хүчингүй болсон, хуулийн хугацаанд нь зарлаагүйгээс 20 946.7 сая төгрөгийн 65 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- БШУС-ын багцын хүрээнд 1 765.6 сая төгрөгийн 23;
- ЭМС-ын багцад 631.3 сая төгрөгийн 9;
- ХАХНХС-ын багцад 2 471.1 сая төгрөгийн 6;
- СС-ын багцад 12 334.2 сая төгрөгийн 3;
- ЗГХЭГ-ын багцад 892.0 сая төгрөгийн 4;
- БХБС-ын багцад 1 146.8 сая төгрөгийн 3 арга хэмжээ тус тус хэрэгжээгүй байна.

- ТЭЗҮ, зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөл хангагдаагүйгээс 6 246.2 сая төгрөгийн 12 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- Нийслэлийн ЗДТГ 4 100.0 сая төгрөгийн 4;
- СС-ын багцад 1 309.1 сая төгрөгийн 2;
- БХБС-ын багцад 226.0 сая төгрөгийн 1;
- УХААС-ын багцад 225.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

- Гүйцэтгэгч байгууллагын ажиллах хүч, техник хангамж дутагдсан болон ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс 10 796.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- БОНХС-ын багцад 3 төсөл, арга хэмжээний 8 027.1 сая;
- ССАЖС-ын багцаас Баянхонгор аймгийн Бууцагаан сумын соёлын төвийн 260.3 сая, Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын 1 700.0 сая, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Шанд багийн соёлын төвийн 250.0 сая төгрөг;
- ХАХНХС-ын багцад 2 арга хэмжээний 748.6 сая төгрөгийн ажил тус тус хэрэгжээгүй.

4.3 Батлагдсан зураг төсөв болон геологийн дүгнэлт өөрчлөгдсөнөөс нэмэлт хөрөнгө шаардагдсан төсөл, арга хэмжээ цөөнгүй байна. Тухайлбал,

- БХИС-ийн “Тэмүүжин өрлөг” сургуулийн барилгын зураг төсөв өөрчлөгдсөн, газар шорооны ажлын явцад геологийн судалгааны дүгнэлт өөрчлөгдсөнөөс 3 300.0 сая төгрөгөөр төсөвт өртөг нэмэгдэх тооцоо гарсан;
- Гандантэгчлэн хийдийн 1080 суудалтай өргөтгөлийн барилга 2008 оноос баригдаж эхэлсэн бөгөөд экспертизээр төсөвт өртөг нь 6 600.0 сая төгрөгөөр нэмэгдэж 18 300.0 сая болсон;
- Нийслэлийн 8 дүүрэгт 14 ширхэг халуун усны барилгын зардалд 1 344.0 сая, Зайсангийн 1.7 км автозамын шинэчлэлд 262.5 сая төгрөгийн төсөв нэмж шаардагдсан.

4.4 ИНЕГ-т 2012 онд хэрэгжиж дуусах төсөл, арга хэмжээнээс 4 616.0 сая төгрөгийн 13 ажил, үйлчилгээ хийгдээгүй байна. Тухайлбал:

- Завхан аймгийн нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас үерийн далангийн ажилд 1 500.0 сая төгрөг;
- Говь-Алтай аймгийн нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далангийн ажилд 900.0 сая төгрөг Заабар ХХК 2008 оноос үргэлжилж байгаа;
- Улаанбаатар хотын бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажилд 1 164.6 сая төгрөг;
- Баруун 4 аймагт онгоц хөөрч буух хатуу хучилттай зурваст гэрэлтүүлгийн систем суурилуулах ажилд 700.9 сая төгрөг Баян өлгий аймагт хэзээ суурилуулах нь тодорхойгүй гэх мэт.

4.5 “УБТЗ” ХНН-ийн хувь нийлүүлэгчдийн хамтарсан хуралдааны шийдвэрийн дагуу дүрмийн санг хоёр үе шаттайгаар 250.0 сая ам. доллараар нэмэгдүүлэхээр УИХ-аас шийдвэрлэжээ.

4.6 Энэ шийдвэрийн дагуу ЗТС-ын багцад 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтаар 170.0 тэрбум төгрөг баталж, 2012 оны 5 дугаар сарын 16-

ны өдрийн Засгийн газрын 166 дугаар тогтоолоор “УБТЗ” ХНН-ийн дүрмийн санг 167.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

4.7 Дээрх хөрөнгө нь арилжааны банкинд байршаад бүтэн жил өнгөрч байхад тодорхой ажил зохион байгуулаагүй, банкинд хадгалагдаж байна.

4.8 Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил дээр тендер зарлан гэрээ байгуулж, санхүүжилт олгосон явдал гарсан байна.Тухайлбал,

- ✚ БХЯ “Энхийн төлөө цогцолбор-Багабаян” амралтын хоорондох 2.8 км хатуу хучилттай автозамын 1750.0 сая төгрөгийн өртөг бүхий тендерийг 2012 оны 7 дугаар сарын 20-нд зарлан 9 дүгээр сард “Насны зам” ХХК-тай гэрээ байгуулсан.Гэвч энэ зам нь 2011 онд хийгдсэн байсан бөгөөд БХС-ын 2008 оны 377 дугаар тушаалаар батлагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй техникийн комисс 2012 оны 1 дүгээр сарын 12-нд шалгаж, зураг төсвийн дагуу бүрэн хийгдсэн гэж дүгнэн ашиглах зөвшөөрөл олгосон байна. 2012 онд 735.0 сая төгрөг “Насны зам” ХХК-д олгосон.2013 оны төсөвт хөрөнгө тусгагдсан.

4.9 Төсвийн тухай хуулиар батлагдсан зарим арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр зориулалтыг нь өөрчилсөн байна. Тухайлбал,

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг

- ✚ 2010 онд (2010-2012 онд 6 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг) 800.0 сая,2011 онд (2010-2013 онд 9 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг) 2 000.0 сая, 2012 онд (2010-2013 онд 10 600.0 сая төгрөгийн төсөвт өртөг) 5 300.0 сая, 2013 онд 500.0 сая төгрөг батлагдсан байна.
- ✚ ТТАХНЭ-ийн шинэ цогцолборын гүйцэтгэгчээр “Шинэ барилга” ХХК шалгарч өнгөрсөн хугацаанд 8100.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэжээ.
- ✚ Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 122 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүнд үйлчлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтад оруулах зорилгоор ХЗЯ-ны харьяа “ТТАХНЭ”, БХЯ-ны харьяа “ЗХКТГ”-ыг нэгтгэн “Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг” болгон өөрчлөн зохион байгуулж, БХЯ-ны харьяанд ажиллуулах шийдвэр гаргасан байна. Дээрх тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТТАХНЭ-ийн барилгын санхүүжилтийг түр хугацаагаар зогсоож, барилгын зориулалтыг өөрчилж, зураг төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж байна.
- ✚ ТТАХНЭ-ийн барилгыг ХЗЯ-ны конторын барилга болгон өөрчлөхөд барилгын материалын үнийн өсөлт, цалин, мөн зориулалтыг өөрчлөн зохион байгуулахад 7 000.0 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардлагатай байна гэсэн тооцоог гаргасан байна.

Орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

4.10 2012 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих автозамын төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын хувьд орон нутагт эрх нь шилжсэн авто замын трассын газар чөлөөлөөгүй, зураг төсөвгүй, машин механизмын хүчин чадал хүрэлцээгүй, гүйцэтгэгч болон түншлэгч компаний ажлын зохион байгуулалт хангалтгүй, захиалагчийн зүгээс тавих хяналт сул зэргээс шалтгаалан гэрээний хугацаанд дараах авто зам ашиглалтанд орох бололцоогүй болжээ.Тухайлбал,

- ✚ Эрдэнэт хотын Наран Шанд багууудын хоорондох авто замын трасс батлагдаагүй;
- ✚ Баянхонгор аймгийн 2 км авто замын 409.4 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэхээр “Их Монгол барилга”ХХК гэрээ байгуулсан бөгөөд ажил эхлэх зөвшөөрөлгүй, зураг баталгаажуулаагүйгээс МХГ ажлыг нь зогсоосон;

- ✚ Булган аймгийн Булган сумын төвийн орон сууцны талбайн 1 км хатуу хучилттай авто зам 23.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу, газар гүйцэт чөлөөлөөгүй;
- ✚ Дорнод аймгийн Ардчиллын гудамж зам засварын 30.3 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу;
- ✚ Төв аймгийн төвийн 3 км авто зам асфальтан хучилт хийгдээгүй, ажлын явц 80.0 хувь;
- ✚ Сэлэнгэ аймгийн өртөөний арын авто машины зогсоолыг шинэчлэх ажлаас 25.7 сая төгрөгийн ажил дутуу;
- ✚ Мөн тус аймгийн “Соёмбо цогцолбор”-ын зам барих 117.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэгчийн буруугаас хугацаанд нь хүлээлгэж өгөөгүй;
- ✚ Сүхбаатар аймгийн Баруун-Урт 2.2 км хатуу хучилттай автозам 138.0 сая төгрөгийн нэмэлт төсөв шаардсан;
- ✚ Ховд аймгийн Манхан суманд төмөр бетон гүүр зураг төсөв байхгүй, ямар гүүр барих нь тодорхойгүй, төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар ажил хийгдээгүй;
- ✚ Завхан аймгийн Тэгшийн голын 50 м модон гүүр, 88.0 сая төгрөгийн өртөгтэй гэрээний хугацаа хэтэрсэн;
- ✚ Нийслэлийн СХД-ийн Хангай зах орчмын үерийн хамгаалалт 4.8 км байгууламж 157.4 сая төгрөгийн ажлын трасс өөрчлөгдсөнөөс хийгдээгүй;
- ✚ Улаанхуаран, Шар хадны замын шинэчлэл 1.5 км зам барих 660.1 сая төгрөгийн ажлын зурагт өөрчлөлт орсон, трасс бүрэн чөлөөлөгдөөгүй;
- ✚ Зүүн салааны 3.6 км авто замын шинэчлэл, шинээр 1.2 км авто зам барих 591.0 сая төгрөгийн ажил нь дутуу, тендер оройтож зарласан;
- ✚ Туул Жин Пан уулзвараас Цайз зах хүртэл 1.2 км замын тендерийг 2 удаа нээлттэй зарлаж, шууд гэрээ байгуулсан, трассад орсон, өөрчлөлт бүрэн хийгдээгүй, 3000.0 сая төгрөг;
- ✚ Дамбадаржаагийн 1.6 км авто зам трассад орсон газар бүрэн чөлөөлөлт хийгдээгүй 394.0 сая төгрөг;
- ✚ СБД-ийн 1 дүгээр хороо Гэндэнгийн уулзварыг шинэчлэх ажил замын трасс орсон газар бүрэн чөлөөлөгдөөгүй;
- ✚ БЗД-ийн Нарны зам Баянмонгол хороолол авто машины нүхэн гарц 900.0 сая төгрөгийн ажлын техникийн нөхцөл хангагдаагүй, Улсын экспертизээс зураг төсвийг зөвшөөрөөгүй;
- ✚ ЧД-ийн Урт цагаан гудамж 0.24 км авто замын газрын асуудал шийдэгдээгүй;
- ✚ Зайсангийн 1.7 км авто зам 1250.0 сая төгрөг бөгөөд батлагдсан хөрөнгө хүрэлцэхгүй болсон;
- ✚ Архангай аймгийн Тариат сумын Суман голын гүүрийн 400.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын зураг төсвийг улсын экспертиз батлаагүй байхад тендер 2 удаа зарлагдаж ажил нь дараа оноос эхэлсэн байна.

4.11 Орон нутагт автозамын улсын байцаагч хяналт хийж байгаа боловч авто зам хэмжих тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байхгүй, боловсон хүчний нөөц, мэрэгжлийн ур чадвар хангалтгүй байна.

4.12 ХЗС-ын багцаас орон нутагт эрх шилжүүлсэн орон нутгийн төлөөлөгчийн байр барих 5 000.0 сая төгрөгөөс 4 877.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан бөгөөд аудитаар дараах зөрчил дутагдал илэрлээ.Тухайлбал,

- ✚ Төв аймгийн Өндөрширээт, Сэргэлэн, Цээл сумдад баригдсан 194.5 сая төгрөгийн орон нутгийн төлөөлөгчийн байрыг орлогод аваагүй;
- ✚ Дорнод аймгийн Дорнод, Баянтүмэн, Булган, Матад, Чойбалсан сумын орон нутгийн төлөөлөгчийн байрыг гэрээний хугацаанд нь гүйцэтгээгүй;
- ✚ Баянхонгор аймгийн Шинэжинст сумын орон нутгийн төлөөлөгчийн байр барих байршил өөрчлөгдснөөс шалтгаалан барилгын ажил оройтож 24.5 сая төгрөгийн ажил гүйцэтгээгдээгүй;
- ✚ Завхан аймгийн сумдад баригдсан орон нутгийн төлөөлөгчийн байранд суулт тооцоогүйгээс хананд цууралт өгсөн, цонх хагарч, хаалга гажсан, ханан пийшин шаардлага хангахгүй, халаалт муу;
- ✚ Сэлэнгэ аймгийн Орхон, Сайхан сумын орон нутгийн төлөөлөгчийн байр гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй;
- ✚ Увс аймгийн Тариалан, Өлгий, Сагил суманд орон нутгийн төлөөлөгчийн байруудын

барилга угсралтын ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн ч агааржуулалтын систем муутайгаас цонх хананд мөөгөнцөр үүссэн эмульс, шохой унасан, паарнаас нь ус гоожсон, хаалганууд нь гажсан, тааз нь нурсан байна.

4.13 Зарим аймгийн Засаг даргын шийдвэрээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн тохиолдол гарсан байна. Тухайлбал,

- + Архангай аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилгын их засварт батлагдсан 30.0 сая төгрөгийн зориулалтыг өөрчилж 15.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан;
- + Өвөрхангай аймгийн Богд суманд 18 км цэвэр усны шугам хоолой тавих ажилд 50.0 сая төгрөг батлагдаж ирснээс 22.0 сая төгрөгөөр ус тээвэрлэх автомашин худалдан авсан, 7.2 сая төгрөгөөр ундны усны худаг засварлах ажил хийсэн.

4.14 Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн ТЕЗ нараас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг төрийн сангийн санхүүжилттэй тулган баталгаажуулж иржээ.

4.15 Гэвч зарим төсөл арга хэмжээний мэдээлэл дутах, хоорондоо зөрөх тохиолдол гарч байгаагаас үзэхэд аймгийн ЗДТГ, Төрийн сангийн хэлтэс орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтэд бүрэн хяналт тавьж чадахгүй байна.

4.16 Гэрээний дагуу төлөвлөгөөт ажлаа гүйцэтгээгүй байж хуурамч гүйцэтгэл гаргасныг хянан үзэлгүйгээр санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

- + Өвөрхангай аймгийн Уянга сумын төвийн 2 км бетон хучилттай авто замын 280.0 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 70.0 хувийг гүйцэтгээч "Үүлэн цамхаг" ХХК хуурамч гүйцэтгэл гарган авсан.
- + Тэмүүжин өрлөг дунд сургуулийн барилгын гүйцэтгээч "Талст Өргөө" ХХК гүйцэтгэлийн баталгааг хуурамчаар үйлдэн 700.0 сая төгрөг авсан.

Хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна

4.17 Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд "2012 оны Төсвийн тухай хуульд заасан төсөл, арга хэмжээний тендер нь зарлагдсан боловч, төсвийн жилд багтаан гэрээ байгуулагдаагүй, дараа оны төсвийн жилд гэрээ байгуулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд урьдчилгаа санхүүжилтийг банкны баталгааг үндэслэн олгох" гэснийг үндэслэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл гараагүй аж ахуйн нэгж, байгууллагад "банкны урьдчилгаа төлбөрийн баталгаа"-гаар хавтгайруулан санхүүжилт олгожээ. Үүнд:

- + Налайх-Зуун мод чиглэлийн 25 км зам барилга угсралтын ажлын урьдчилгаа 1 405.8 сая төгрөг ("БНХАУ-ын Барилга, хот байгуулалтын гуравдугаар барилга байгууламж" ХХК);
- + Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км замын шинэчлэлийн ажлын урьдчилгаа 755.7 сая төгрөг ("Дафенг" ХХК);
- + Налайх-Агуйтын хөтөл чиглэлийн 24.1 км замын шинэчлэлийн ажлын урьдчилгаа санхүүжилт 1 079.5 сая төгрөг ("Замын битум" ХХК);
- + Элсэн тасархай-Арвайхээр чиглэлийн 40.0 км хатуу хучилттай авто замын шинэчлэлийн ажлын урьдчилгаа санхүүжилт 625.6 сая төгрөг ("Үйлсийн зам" ХХК);
- + Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажлын урьдчилгаа 1 500.0 сая төгрөг (БНБУ-ын "Контракс ЕАД" ХХК);

- ✚ Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах автовокзалын барилга угсралтын ажлын урьдчилгаа санхүүжилт 2073.0 сая төгрөг ("Бридж констракшн" ХХК);
- ✚ Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлын урьдчилгаа санхүүжилт 581.7 сая төгрөг ("Үүрэг трейд" ХХК);
- ✚ Завхан аймгийн Донойн хөндийн нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далангийн ажлын урьдчилгаа санхүүжилт 1500.0 сая төгрөг ("Хурдны зам" ХХК);
- ✚ Тавцант ачааны тэргэнцэр PD 4 ширхэгийг нийлүүлэх ажил урьдчилгаа 59.9 сая төгрөг ("АТТА ЧР" ХХК).

4.18 Санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагын хүний болон техникийн хүчин чадлыг тооцолгүйгээр шууд олгосон нь тухайн төлөвлөсөн ажил хугацаа алдах, хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

4.19 Түүнчлэн захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид тавих хяналт, Сангийн яамны хөрөнгө оруулалтын хэлтсээс захиалагч, гүйцэтгэгчид тавих хяналт, орон нутгийн мэргэжлийн байгууллагын хяналт уялдаа, үр дүн муутай байна.

4.20 ТБОНӨХБАУХАТХ-ийн 29 дүгээр зүйлд заасны дагуу захиалагч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж байгаа боловч гэрээнд нөхцөл, хоёр талын эрх үүргийг хэт ерөнхий тусгаснаас үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож чадахгүйд хүрч байна.

4.21 Гэрээний гүйцэтгэл хангалтгүй байгаа зөрчил жил бүр давтагдаж байгаа боловч өнөөг хүртэл ганц ч гүйцэтгэгч "найдваргүй" жагсаалтад бүртгэгдээгүй байна.

4.22 Тухайлбал, ихэнх тохиолдолд захиалагчийн хяналтын бүрэлдэхүүнд ашиглагчийн төлөөллийг оролцуулдаггүйгээс талбайн байнгын хяналт бүрэн хийгддэггүй, Сангийн яамны хөрөнгө оруулалтын хэлтэс гүйцэтгэлийн бичиг баримт хянах төдийгээр санхүүжилтийн эрхийг нээж байна.

4.23 Цаашид гэрээнд тухайн хөрөнгө оруулалтыг ашиглагч байгууллагын болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөллийг оролцуулж хяналтыг хэрэгжүүлбэл гүйцэтгэлийн чанар, үр дүн сайжрах боломж байна.

4.24 Сангийн яамны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Төрийн сангийн газар, ТЕЗ-дын холбогдох ажилтнуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын санхүүжилт удаашрах, баримт материал, судалгаа олдохгүй байх, тайлан мэдээ алдаа, зөрүүтэй гарах дутагдал илэрч байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:


1. Улсын төсвөөс 2008-2011 онд нийт 2 209.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2008 онд 460.0 тэрбум төгрөг байсан бол 2011 онд 901.4 тэрбум төгрөгт хүрч, жилд дунджаар 32.7 хувиар өссөн дүн гарч байна.
